



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/01

Сүмбэр сум

Бүтэц, орон тоо, албан хаагчдын албан тушаалын зэрэглэл,
цалин, нэмэгдлийг шинэчлэн тогтоох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дугаар зүйлийн 101.1, Төрийн албаны тухай хууийн 57 дугаар зүйлийн 57.1, 57.2.2, 57.2.4, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын 2.10, Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолын хавсралт "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт", Монгол Улсын Засгийн газрын "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 2022 оны 488 дугаар тогтоолын 2,5 дугаар хавсралт, "Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2022 оны 489 дүгээр тогтоол, Засгийн газрын 2022 оны 491 дүгээр тогтоол "Журамд өөрчлөлт оруулах тухай", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам"-ын 4 дэх заалт, Говьсүмбэр аймгийн Засаг даргын "Байгаль орчин, аялал жуулчлалын газрын орон тоог шинэчлэн батлах тухай" 2023 оны А/09 дүгээр захирамж, "Төрийн албан хаагчдын цалин, нэмэгдлийг шинэчлэн батлах тухай" 2023 оны А/13 дугаар захирамжийн 2-р хавсралт, "Төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох тухай" 2023 оны А/14 дүгээр захирамжийн 1-р хавсралт, "Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн хэмжээг батлах тухай" 2023 оны А/15 дугаар захирамжийн 1-р хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын бүтэц, орон тоог Нэгдүгээр хавсралтаар, албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, үндсэн цалин, нэмэгдлийг Хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай

2.Хариуцсан чиг үүргийн хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангаж, ажиллахыг нийт албан хаагчдад даалгасугай.

3.Албан хаагчдын албан тушаалын цалин, холбогдох нэмэгдлийг хавсралтанд заасны дагуу батлагдсан төсвийн цалингийн зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.МӨНХ-ЭРДЭНЭ

D:/bichig hereg/ Tushaal.doc/
4223010046

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын
даргын 2023 оны 01 дүгээр сарын 26-ны
өдрийн 1/0 дүгээр тушаалын 1-р хавсралт

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Албан тушаал	Албан тушаалын зэрэглэл	Орон тоо
1	2	3	4
1	Газрын дарга	T3-4	1
2	Байгаль орчны улсын хяналтын байцаагч	T3-7	1
3	Байгаль орчны бодлогын хэрэгжилт, хяналт шинжилгээ, үнэлгээ, хүний нөөц, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн	T3-8	1
4	Аялал жуулчлал тусгай хамгаалалттай газар нутаг, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
5	Байгаль орчны үнэлгээ, усны асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
6	Хүрээлэн буй орчны бохирдол, байгалийн гамшиг, газрын асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
7	Ой, цөлжилт, биологийн олон янз байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
8	Сүмбэр сумын байгаль хамгаалагч	T3-9	1
9	Нягтлан бодогч	TY-8	1
10	Архив, бичиг хэргийн эрхлэгч, нярав	TY-5	1
11	Улсын тусгай хамгаалалттай газар нутаг хариуцсан харуул хамгаалалтын ахлагч	TY-3	1
12	Жолооч	TY-3	1
13	Үйлчлэгч	TY-1	1
	Нийт		13